



## **ДУЛАМЖАВЫН ГОМБОЖАВ**

Улаанбаатар хотын захиргааны дарга 1927-1929 он  
Улаанбаатар аймгийн дарга 1930-1931 он  
Улаанбаатар хотын захирах яамны дарга 1936-1939 он

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын даргаар гурван удаа сонгогдон ажиллаж байсан Д.Гомбожав нь хуучин Түшээт хан аймгийн Ахай гүний хошуу, одоогийн Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 1898 онд төрсөн.

Гомбожав, эцгээ насан өөд болсны дараа эх Дуламжавын гар дээр өсч хүмүүжсэн ядуу ард гаралтай н. Зургаа, долоон настайдаа Цэргийн яамны түшмэл гүн Балдан гэдэг хүнээр бичиг үсэг заалган, 15 наснаас Хиагтын төмөр утасны хороонд манаач.

Хүдэрийн харуулын цэрэгт алба хаасан. 1920 оноос гамин цэрэгтэй тэмцэн явсаар 1921 онд ардын журамт цэрэгт элсэн Д.Сүхбаатарын удирдлагаар 1921 оны гуравдугаар сарын 18-нд Хиагтыг чөлөөлөхөд дөрвөн пулемётын нэгний наводчигоор байлдаж, дараа нь Хүрээг чөлөөлөхөд

пулемётын наводчик явсан ардын хувьсгалын анхны партизан цэрэг байсан.

1921-1927 онд ардын цэрэгт салаа, хороо, бригадын дарга, суртлын сургагч, цэргийн ерөнхий сургуулийн комиссар, цэргийн шүүхийн дарга, 1933 онд бүх цэргийн прокурор, 1934-1936 онд БНМАУ- аас Тагна Тува улсад суух элчин сайдаар ажиллаж байжээ. Тэрээр Засгийн газрын эрхлэх товчооны 1927 оны 186, 1930 оны зургаа, Сайд нарын зөвлөлийн 1936 оны 32 дугаар тогтоол болон хотын захиргааны IV, VI, VII, VIII их хурлуудаас 1927-1929, 1930-1931, 1936-1939 онд Улаанбаатар хотын захиргааны даргаар гурван удаа сонгогдон ажиллаж байсан юм.

1931 оны 9 дүгээр сарын 21-нд Улсын бага хурлын тэргүүлэгчид Засгийн газрын хамтарсан хурлаар Төв аймаг, Улаанбаатар хотын захиргаа нутаг дэвсгэрийг нэгтгэн төвлөрүүлж Улаанбаатар аймгийн захиргаа байгуулах сонгуулийг 10 дугаар сарын 1-ний өдөр хийхээр тогтож байжээ. Улаанбаатар, Төв аймаг хоёрыг нийлүүлсэн нь нийслэл хотын бие даасан байдлыг алдагдуулж, хотын хөгжилд сөрөг нөлөө үзүүлсэн учир 1931 онд дахин салгаж, засаг захиргааны бие даасан хоёр нэгж болгожээ.

Гурав дахь удаагаа хотын даргаар сонгогдон ажиллаж байх үед 1937 оны 2 дугаар сарын 13-нд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн нийслэл Улаанбаатар хотыг Захирах яам болгожээ. Хотын даргыг Сайд нарын Зөвлөлийн гишүүн болгожээ. Хотын ариун цэврийг сайжруулахад ихэд санаа тавьж, гудамж талбайд нэр, дугаар олгох, оршин суугчдаа бүртгэлтэй болгох ажлыг эхлэн ихэд амжилтад хүргэжээ. Гэгээрэл боловсролыг хөгжүүлэн, ардыг үндэсний хэл бичигт сурган боловсруулах, өнчин ядуусыг тэтгэх талаар дуулиантай ажил өрнүүлж байжээ. Бие угаах, бие засах газар, дэн буудал, галын аюулаас хамгаалах газар /усан хөөрөг/ зэрэг олон зүйлийг хотод шинээр байгуулж, санхүү, албан татварын данс бүртгэлийг эмхлэн цэгцтэй болгох зэрэг маш чухал арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байсан.

Д.Гомбожав 1924 онд Монгол улсын анхдугаар их хурал болон IV, VI их хурлуудад Улаанбаатар хотоос төлөөлөгчөөр сонгогдон оролцож, Улсын бага хурлын гишүүнээр сонгогдож байжээ. Цэргийн албанд ноогдсон үүргээ сайн биелүүлсэн учир 1923 онд 100 лан мөнгө, ардын хувьсгалын 10 жилийн ой болон дараа нь цэргийн гавьяаны одонгоор хоёр удаа шагнагдсан байна. 1939

онд хилс хэрэгт баригдан шийтгүүлж, ял эдэлж байгаад 1939 оны сүүлчээр суллагдаж, 1962 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 57 дугаар зарлигаар уул хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгажээ. Тэрээр хотын захиргааны даргаар гурван удаа ажиллах хугацаандаа нийслэл хотоо хөгжүүлэх, ард түмний аж байдлыг сайжруулах, засаг захиргааны зохион байгуулалт бүтцийг шинэчлэн бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ажилласан.